ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он


Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Даваанямм

Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@ audit.gov.mn

Ньюбаланс аудит ХХК-ийн Захирал: Б.Лхагвадорж

Утас: 99101901 Цахим хаяг:

Newbalance.lhagvaa@gmail.com

Аудитор: Ё.Байгалмаа

Утас: 99025579 Цахим хаяг: yobaigal5579@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ........................................ 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................ 4
3. Аудитын тайлан........................................ 12
3.1 Ерөнхий зүйл........................................ 12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................ 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................ 12
3.4 Материаллаг байдал ........................................ 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........................................ 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........................................ 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........................................ 15
3.8 Аудитын гол асуудал ........................................ 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................ 16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................ 16
4. Аудитын илрүүлэлт ........................................ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................ 16

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| | |
| | |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.09.25 № 01/217

танай ______________ -ны № ______________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.МЯГМАРМАА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **216,042,740.85** | **223,587,091.06** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 216,042,740.85 | 223,587,091.06 |
| **351** | **Түүхий эд материал** | 120,613,845.05 | 122,361,886.96 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 118,020,375.05 | 121,335,436.96 |
| 35130 | Эм боох материал | 2,593,470.00 | 1,026,450.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 76,818,895.80 | 78,585,204.10 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 14,106,837.00 | 4,320,987.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 12,320,220.00 | 11,953,798.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,700,000.00 | 3,700,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,613,790.00 | 13,532,370.30 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 45,078,048.80 | 45,078,048.80 |
| 35600 | Мал амьтад | 18,610,000.00 | 22,640,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,194,326,051.28** | **4,136,700,851.87** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,194,326,051.28 | 4,136,700,851.87 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,066,602,051.28 | 4,008,745,351.91 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,929,255,889.90 | 3,929,255,889.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -177,352,541.88 | -308,306,475.60 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 243,787,443.21 | 139,054,789.68 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -206,154,666.46 | -31,773,687.98 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 83,967,523.31 | 83,732,553.09 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -43,215,578.46 | -24,636,684.76 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 229,152,669.50 | 229,152,669.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -37,265,074.84 | -52,557,788.92 |
| 39217 | Ном | 44,426,387.00 | 44,824,087.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 127,724,000.00 | 127,955,499.96 |
| 39301 | Програм хангамж | 1,075,000.00 | 581,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -825,000.00 | -100,000.04 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 127,474,000.00 | 127,474,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,410,368,792.13** | **4,360,287,942.93** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,009,300.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,009,300.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 1,009,300.00 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 450,000.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 559,300.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 559,300.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,409,359,492.13** | **4,360,287,942.93** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,409,359,492.13 | 4,360,287,942.93 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 548,092,734.40 | 548,092,734.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 548,092,734.40 | 548,092,734.40 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,440,605,308.70 | 2,391,533,759.50 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,440,605,308.70 | 2,440,605,308.70 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -49,071,549.20 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,420,661,449.03 | 1,420,661,449.03 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,410,368,792.13** | **4,360,287,942.93** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,064,183,491.20** | **1,511,219,626.59** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,052,472,211.20** | **1,485,769,885.77** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,558,237,911.20 | 108,092,085.77 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,558,237,911.20 | 108,092,085.77 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.20 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,558,237,911.00 | 108,092,085.77 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | 328,961,900.00 | 312,164,700.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 1,165,272,400.00 | 1,065,513,100.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,165,272,400.00 | 1,065,513,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **11,711,280.00** | **25,449,740.82** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,711,280.00 | 25,449,740.82 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 8,795,940.82 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,711,280.00 | 16,653,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,559,177,620.92** | **1,560,291,175.79** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,559,177,620.92** | **1,560,291,175.79** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,473,282,579.01 | 1,530,675,692.79 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 857,384,933.80 | 842,301,401.00 |
| 210101 | Үндсэн цалин | 727,380,333.80 | 631,064,717.00 |
| 210102 | Нэмэгдэл | 59,871,400.00 | 174,116,684.00 |
| 210104 | Урамшуулал | 70,133,200.00 | 37,120,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 115,907,461.16 | 113,641,112.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,703,496.16 | 79,960,295.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,801,041.00 | 8,413,883.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,040,733.00 | 6,742,510.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,760,208.00 | 1,684,066.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,601,983.00 | 16,840,358.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 293,162,105.30 | 305,814,014.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,592,214.30 | 5,737,114.00 |
| 210302 | Түлш, халаалт | 287,514,891.00 | 300,021,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 55,000.00 | 55,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,689,545.00 | 29,602,245.82 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,392,100.00 | 11,345,191.82 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,306,190.00 | 3,029,170.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,445,805.00 | 1,590,884.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,126,100.00 | 74,330.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 233,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,536,350.00 | 12,732,670.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,650,000.00 | 830,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 37,988,995.00 | 50,255,946.70 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,215,470.00 | 2,387,620.00 |
| 210502 | Хоол, хүнс | 36,773,525.00 | 47,868,326.70 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,570,469.00 | 2,765,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,570,469.00 | 2,765,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 773,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 773,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,005,800.00 | 2,758,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,505,800.00 | 1,750,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 133,573,269.75 | 182,763,473.27 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,357,180.20 | 18,886,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,009,400.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 130,206,689.55 | 163,877,473.27 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 85,895,041.91 | 29,615,483.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,207,620.00 | 27,613,466.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,181,120.00 | 26,683,466.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,026,500.00 | 930,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 417,131.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 417,131.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,799,810.87 | 1,584,886.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,799,810.87 | 1,584,886.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 64,887,611.04 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 64,887,611.04 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,505,005,870.28** | **-49,071,549.20** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,505,005,870.28** | **-49,071,549.20** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 420,618,734.40 | 245,973,663.00 | 49,797,739.07 | 716,390,136.47 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **420,618,734.40** | **245,973,663.00** | **49,797,739.07** | 716,390,136.47 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -20,216,004.50 | -20,216,004.50 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **548,092,734.40** | **1,420,661,449.03** | **2,440,605,308.70** | 4,409,359,492.13 |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **548,092,734.40** | **1,420,661,449.03** | **2,440,605,308.70** | 4,409,359,492.13 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **548,092,734.40** | **1,420,661,449.03** | **2,440,605,308.70** | 4,409,359,492.13 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -49,071,549.20 | -49,071,549.20 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **548,092,734.40** | **1,420,661,449.03** | **2,391,533,759.50** | 4,360,287,942.93 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,505,945,580.20** | **1,405,572,640.82** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,494,234,300.20** | **1,377,677,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.20 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.20 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.20 | 00.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 328,961,900.00 | 312,164,700.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 1,165,272,400.00 | 1,065,513,100.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,165,272,400.00 | 1,065,513,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **11,711,280.00** | **27,894,840.82** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,711,280.00 | 27,894,840.82 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 8,795,940.82 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,711,280.00 | 19,098,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,459,465,396.37** | **1,379,148,940.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,459,465,396.37** | **1,379,148,940.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,378,432,464.46** | **1,344,817,468.82** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 857,084,933.80 | 842,301,401.00 |
| 210101 | Үндсэн цалин | 727,080,333.80 | 631,064,717.00 |
| 210102 | Нэмэгдэл | 59,871,400.00 | 174,116,684.00 |
| 210104 | Урамшуулал | 70,133,200.00 | 37,120,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 115,907,461.16 | 113,641,112.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,703,496.16 | 79,960,295.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,801,041.00 | 8,413,883.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,040,733.00 | 6,742,510.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,760,208.00 | 1,684,066.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,601,983.00 | 16,840,358.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 293,162,105.30 | 305,814,014.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,592,214.30 | 5,737,114.00 |
| 210302 | Түлш, халаалт | 287,514,891.00 | 300,021,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 55,000.00 | 55,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,193,165.00 | 12,840,625.82 |
| 210401 | Бичиг хэрэг | 833,400.00 | 907,341.82 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,334,000.00 | 3,029,170.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,445,805.00 | 1,590,884.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,142,100.00 | 2,519,430.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,752,460.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,685,400.00 | 4,793,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 63,403,000.00 | 56,232,316.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,939,340.00 | 820,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 40,577,360.00 | 53,520,918.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 18,886,300.00 | 1,890,798.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 912,219.00 | 6,365,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 1,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 912,219.00 | 4,765,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 773,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 773,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,005,800.00 | 3,024,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,505,800.00 | 2,016,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,763,780.20 | 3,824,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,014,180.20 | 1,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,749,600.00 | 2,824,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **81,032,931.91** | **34,331,472.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,345,510.00 | 32,329,455.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,319,010.00 | 31,399,455.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,026,500.00 | 930,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 417,131.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 417,131.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,799,810.87 | 1,584,886.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,799,810.87 | 1,584,886.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 64,887,611.04 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 64,887,611.04 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **46,480,183.83** | **26,423,700.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **46,480,200.00** | **26,423,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **46,480,200.00** | **26,423,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 46,480,200.00 | 26,423,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 46,480,200.00 | 26,423,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-46,480,200.00** | **-26,423,700.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -16.17 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 16.17 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | **Зөрүү** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,377,677,800.00** | **1,375,719,123.00** | **1,958,677.00** | 99.9% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,377,677,800.00** | **1,375,719,123.00** | **1,958,677.00** | 99.9% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,345,276,000.00** | **1,343,389,668.00** | **1,886,332.00** | 99.9% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **835,688,800.00** | **835,571,478.00** | **117,322.00** | 100.0% |
| 210101 | Үндсэн цалин | 603,142,800.00 | 624,334,794.00 | **-21,191,994.00** | 103.5% |
| 210102 | Нэмэгдэл | 184,346,000.00 | 174,116,684.00 | **10,229,316.00** | 94.5% |
| 210104 | Урамшуулал | 48,200,000.00 | 37,120,000.00 | **11,080,000.00** | 77.0% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 112,817,900.00 | 112,768,275.00 | **49,625.00** | 100.0% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 79,390,400.00 | 79,356,655.00 | **33,745.00** | 100.0% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,356,900.00 | 8,353,724.00 | **3,176.00** | 100.0% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,685,500.00 | 6,681,530.00 | **3,970.00** | 99.9% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,671,400.00 | 1,670,606.00 | **794.00** | 100.0% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,713,700.00 | 16,705,760.00 | **7,940.00** | 100.0% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 307,398,900.00 | 305,814,014.00 | **1,584,886.00** | 99.5% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,500,000.00 | 5,737,114.00 | **762,886.00** | 88.3% |
| 210302 | Түлш, халаалт | 300,021,900.00 | 300,021,900.00 | **00.00** | 100.0% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 877,000.00 | 55,000.00 | **822,000.00** | 6.3% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,283,100.00 | 10,261,184.00 | **21,916.00** | 99.8% |
| 210401 | Бичиг хэрэг | 568,500.00 | 555,000.00 | **13,500.00** | 97.6% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | 2,999,470.00 | **530.00** | 100.0% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,568,400.00 | 1,440,884.00 | **127,516.00** | 91.9% |
| 210404 | Ном, хэвлэл | 473,800.00 | 472,030.00 | **1,770.00** | 99.6% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 597,000.00 | 00.00 | **597,000.00** | 0.0% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,075,400.00 | 4,793,800.00 | **-718,400.00** | 117.6% |
| **2105** | **Нормативт зардал** | 52,529,500.00 | 52,500,717.00 | **28,783.00** | 99.9% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 377,700.00 | 377,001.00 | **699.00** | 99.8% |
| 210502 | Хоол, хүнс | 50,260,900.00 | 50,232,918.00 | **27,982.00** | 99.9% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,890,900.00 | 1,890,798.00 | **102.00** | 100.0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,765,800.00 | 12,765,800.00 | **00.00** | 100.0% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,000,000.00 | 8,000,000.00 | **00.00** | 100.0% |
| 210604 | Урсгал засвар | 4,765,800.00 | 4,765,800.00 | **00.00** | 100.0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 852,900.00 | 773,200.00 | **79,700.00** | 90.7% |
| 210702 | Дотоод албан томилолт | 852,900.00 | 773,200.00 | **79,700.00** | 90.7% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,089,600.00 | 2,085,500.00 | **4,100.00** | 99.8% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,081,600.00 | 1,077,500.00 | **4,100.00** | 99.6% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | 1,008,000.00 | **00.00** | 100.0% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10849500.00 | 10849500.00 | **00.00** | 100.0% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 1,000,000.00 | **00.00** | 100.0% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,849,500.00 | 9,849,500.00 | **00.00** | 100.0% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 32401800.00 | 32329455.00 | **72,345.00** | 99.8% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 32,401,800.00 | 32,329,455.00 | **72,345.00** | 99.8% |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 31,401,800.00 | 31,399,455.00 | **2,345.00** | 100.0% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 930,000.00 | **70,000.00** | 93.0% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,377,677,800.00 | 1,375,719,123.00 | **1,958,677.00** | 99.9% |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,065,513,100.00 | 1,065,139,309.00 | **373,791.00** | 100.0% |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,065,513,100.00 | 1,065,139,309.00 | **373,791.00** | 100.0% |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 312,164,700.00 | 310,579,814.00 | **1,584,886.00** | 99.5% |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 312,164,700.00 | 310,579,814.00 | **1,584,886.00** | 99.5% |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 72.00 | 72.00 | **00.00** | 100.0% |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | **00.00** | 100.0% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 44.00 | 44.00 | **00.00** | 100.0% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 27.00 | 27.00 | **00.00** | 100.0% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **27,851,500.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **27,851,500.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 27,851,500.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 6,729,923.00 |
| 210101 | Үндсэн цалин | 6,729,923.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 872,837.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 603,640.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 60,159.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 60,980.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 13,460.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 134,598.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,977,141.82 |
| 210401 | Бичиг хэрэг | 352,341.82 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 150,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,445,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,731,599.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 443,599.00 |
| 210502 | Хоол, хүнс | 3,288,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,540,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,540,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 27851500.82 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 27,851,500.82 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,794,850.82 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,056,650.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалтай холбоотой 1 алдаа зөрчил, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн 1 зөвлөмжийг тус тус тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Лхагвадорж, аудиторын туслах Ё.Байгалмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын чанарын менежер Д.Гэрэлчулуун гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь стратегийн төлөвлөгөөндөө багш, суралцагч, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулж, бие даан сурах чадварт ахиц гаргаж, зөв сэтгэлтэй, зөв үзэлтэй, зөв үгтэй, зөв үйлдэлтэй эрдэм боловсролтой монгол хүн төлөвшүүлэх зорилгыг тусгасан орон нутгийн төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

## 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,559.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 31.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 23.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50.1 сая төгрөгөөр буюу 1,1 хувиар буурсан байна. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна.

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0,0 | 0,0 | 0,0 |
| Бараа материал | 216.0 | 223.6 | -7.6 |
| Биет хөрөнгө | 4,066.6 | 4,008.7 | 57.9 |
| Биет бус хөрөнгө | 127.7 | 128.0 | -0.3 |
| **Нийт хөрөнгө** | **4,410.4** | **4,360.3** | **50.1** |
| Дансны өглөг | 1.0 | 0,0 | 1.0 |
| Засгийн газрын хувь оролцоо | 548.1 | 548.1 | 0 |
| Хуримтлагдсан үр дүн | 2,440.6 | 2,391.5 | 49.1 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,420.7 | 1,420.7 | 0,0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,420.7** | **1,420.7** | **0.0** |

Бараа материалын дансны үлдэгдэл 223.6 сая төгрөг болж, -7.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд тусгай зориулалтын материал, барилгын засварын материал, хүнсний материал зэрэг дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ. Тайлант хугацаанд 0.8 сая төгрөгийн малыг актаар хассан байна.

Биет хөрөнгийн дансны үлдэгдэл 4,008.7 сая төгрөг болж, 57.9 сая төгрөгөөр буурсан нь дахин үнэлж орлого авсан хөрөнгийг данснаас хасахаас гадна ашиглалтын хугацаа нь дуусч дахин ашиглах боломжгүй акталж устгасан үндсэн хөрөнгийг данснаас хассантай холбоотой.

Дансны өглөг данс үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо данс 548.1 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 2,391.5 сая төгрөг, Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 1,420.7 сая төгрөг байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,511.2 сая төгрөг, нийт зардал 1,560.3 сая төгрөг, тайлант үеийн үр дүн -49.1 сая төгрөг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд нийт цэвэр өмчийн дүн 4,360.3 сая төгрөг байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль 2021 оны төсвийн төслийг 1,862.6 сая төгрөгөөр тооцон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд 1,290.4 сая төгрөгөөр анх баталж, 87.3 сая төгрөгөөр төсвийн тодотгол хийж, 1,377.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд 1,377.7 сая төгрөг батлагдсанаас 1,377.7 сая төгрөгийн урсгал санхүүжилт авч, 1,375.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж 2.0 сая төгрөг хэмнэж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсвөөс 10 хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 19.1 сая төгрөг, Боловсролын газраас боловсролын шинэчлэлийн хүрээнд “Богцтой хичээл” төслийн санхүүжилт 8.8 сая төгрөгийг тус тус хүлээн авч, боловсролын чанарын шинэчлэл болон бусад үйл ажиллагаанд 27.86 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 0.04 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхий нийтийг хамарсан Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, хөл хорионы үед сурагчдын хичээл, хүүхдийн дунд зохиогдох хичээлээс гадуурх сургалт хүмүүжлийн ажлын цар хүрээ хязгаарлагдмал байдалтай байсан тул цахим болон зайны сургалтууд тодорхой хугацаанд явагдсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж төсөвт 30.0 сая төгрөгийн хасалт өөрчлөлт, 2.0 сая төгрөгийг төвлөрүүлж хэмнэлт гаргасан байна. Үүнд: Цалин хөлс болон НДШ-с 0.2 сая төгрөг, тогтмол зардлаас 1.6 сая төгрөг, хоолны зардлаас 20.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс 10.2 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд 18 мэдээлэлийг хугацаа хоцроож дутуу мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим хуулийн нийцлийн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын хэрэгжилтийг хянан үзлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснийг аудитаар дахин хянахад хэрэгжсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоог дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 45.1 сая төгрөгийн алдаа, 1 зөрчил илрүүлж 41.8 сая төгрөгийн алдааг залруулж, 2 зөвлөмж өгсөн болно.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар үндсэн хөрөнгийн элэгдлийг 41.8 сая төгрөгөөр дутуу тооцоолсныг залруулсан болно.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Бараа материалтай холбоотой***

***1.1*** *<u>Илрүүлэлт:</u>* Гэрээтэй байгууллагаасаа хүнс авахдаа гэрээний үнийг зөрчиж 3.3 сая төгрөгийн зөрчил илэрч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

***1.2*** *<u>Өгсөн зөвлөмж:</u>* Гэрээний үүргийг биелүүлж зөрчихгүй байх.

***2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой***

2.1. *<u>Илрүүлэлт:</u>* Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд 18 мэдээлэлийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2. *<u>Өгсөн зөвлөмж</u>*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.”*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*”-д заасан мэдээллийг тухай бүр нэгдсэн системд мэдээлж байх,

цээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль | 3 | 45.1 | 1 | 41.8 | | | | | 2 | 3.3 |

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР Э.БАТ-ЭРДЭНЭ

АУДИТОР Б.ДАВААНЯМ

БЭЛТГЭСЭН:

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Б.ЛХАГВАДОРЖ

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР Д.ГЭРЭЛЧУЛУУН

АУДИТОРЫН ТУСЛАХ Ё.БАЙГАЛМАА